# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1996 оны 01 дүгээр сарын 25 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Худалдаа үйлчилгээний төв байгуулах тухай

1.Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын саналыг үндэслэн тус дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээний "Меркурий" төвийг нээн ажиллуулахыг "Гурван-Эвтэн" компанид зөвшөөрсүгэй.

2."Меркурий" төвийн үйл ажиллагаанд зохих хяналт тавьж, дэг журам, зохион байгуулалт, ариун цэврийн шаардлага хангуулж ажиллахыг Сүхбаатар дүүргийн Засаг дарга \Г.Будрагчаа\, Эрүүл ахуй,халдвар судлалын төв \Ч.Үржээ\, Хотын Цагдаагийн газар \Ч.Амарболд\ -т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Ц.БААСАНЖАВ